

ТӨВ АЗИ: ХӨГЖИЛ БА АНУ-ЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

*М.Хурметхан**

ЗХУ мөхсөний дараа АНУ нь Төв Азийн улсууд болох Казахстан, Киргизстан, Тажикстан, Узбекистаны коммунизмээс улс төрийн ардчилсан тогтолцоо болон зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг бүх талаар дэмжиж ирсэн бөгөөд дэмжиж байна. Туркменстаны онцгой нөхцөл байдал нь түүнд туслах боломжийг хааж байгаа юм.

АНУ-ын Төв Ази дахь стратегийн ашиг сонирхол нь гурван зангилаанаас бүрдэнэ. Үүнд:

- Аюулгүй байдал, терроризмын эсрэг тэмцэх зэвсэг үл дэлгэрүүлэх, хар тамхины наймааг таслан зогсоох,
- Эрчим хүч, Каспийн газрын тос, байгалийн хийг дэлхийн зах зээлд үр ашигтай найдвартай зөөвөрлөх, эрчим хүчний орлогыг өсгөн, түүнийг эдийн засгийн тогтвортой өсөлтөд ашиглах;
- Мөн өөрчлөн байгуулалт: энэ нь эдгээр улсуудын ардчилал болон зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг өөртөө агуулах бөгөөд хүний эрхийг дээдлэх, эрх чөлөө, хүлцэн тэвчих болон хөгжил цэцэглэлтийг дэлгэрүүлэхэд оршино.

Терроризмын эсрэг тэмцэл. –Төв Азийн улсууд АНУ-аас газар зүйн хувьд алс хол орших хэдий ч АНУ-ын амин чухал эрх ашиг энд бий. 2001 оны 9-р сарын 11-нээс хойш АНУ нь Төв Азид терроризмын эсрэг тэмцэлд анхаарлаа хандуулж, хөтлөн явуулах болсон бөгөөд террорист бүлэглэлүүдийн нөлөөг таслан зогсоов. АНУ нь Афганистанд Талибаны дэглэмийг түлхэн унгасан нь Афганистантай шууд хил залгадаг Төв Азийн 5 улсын гурвынх нь аюулгүй байдал бэхжихэд чухал нөлөө үзүүлэв. АНУ-ын Афганистанд Талибаны эсрэг хийсэн Эрх олгох үйл ажиллагааг бүх таван улс олон талаар дэмжиж тусалсан байна. Мөн Иракийн сэргээн босголтод оролцуулахаар Казахстан, Узбекистан өөрийн цэргийн суманг илгээжээ.

АНУ-ын хүчин чармайлт. – АНУ нь Төв Азид жинхэнэ аюулгүй болон тогтвортой байдлыг хангахын төлөө ихээхэн хүчин чармайлт тавьж байна. Төв Азийн ард түмнүүдийн хөгжил цэцэглэлтийг хангах гол нөхцөл болох ардчилал, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, хүний

*М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

эрхийг дээдлэх, хуульд захирагдах болон Төв Азийн улсууд бие биетэйгээ хамтран ажиллахад бэлэн байх явдлыг хэвшүүлэхийн төлөө АНУ маш их ажил хийж байна. АНУ нь Төв Азийн улсуудын дотоод шинэчлэл өөрчлөлтийг дэмжихийн хамт, тэдгээр улсуудын хилийн хамгаалалтыг бататгах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрэхээс сэрэмжлүүлэх, хар тамхи болон бусад хууль бус барааг зөөвөрлөх явдлыг таслан зогсооход туслаж, хэрэгцээтэй нарийн тоног төхөөрөмжөөр хангаж байна. Тухайлбал, АНУ нь Төв Азийн улсууд иргэний нийгэм байгуулах, улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг дэмжих, терроризм болон гэмт хэргийн эсрэг тэмцэхэд нь зориулан 2003 оны санхүүгийн жилд 286 сая ам.долларын тусламжийг үзүүлжээ.

Солилцоо бол өөрчлөлтийг тэтгэх амин чухал хэрэгсэл. Солилцооны хөтөлбөрүүд нь ардчилал, тэвчээр болон иргэний нийгэм байгуулах явцыг бэхжүүлэхэд үр дүнгээ өгч байна. АНУ нь 1993 оноос эхлэн богино хугацааны мэргэжил дээшлүүлэх болон урт хугацааны эрдэмтдийн бэлтгэлд Төв Азийн орнуудын 13000 иргэнийг хүлээн авчээ. Эдгээр программууд нь оролцогчдод зах зээлийн ардчиллыг нүдээр үзэж, биеэр мэдрэх сайхан боломжийг олгодог байна. Мөн АНУ нь Төв Азид Америкийн бие даасан их сургуулиуд байгуулахыг дэмжиж байгаа бөгөөд тийм их сургуулийн нэг нь Бишкект ажиллаж, бүс нутгийн шинжлэх ухааны чухал төвийн үүрэг гүйцэтгэж байна. 2004 оны хувьд эдгээр солилцооны программуудыг хэрэгжүүлэхэд 2004 оны санхүүгийн жилд 100 сая ам.доллар төсөвлөхийг санал болгожээ.

Бүс нутгийн тогтвортой байдал: Эдийн засгийн хамтын ажиллагаа интеграци Төв Азийн орнуудын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграци бараг үгүй юм. Үүнд: Зарим улс хилээ хаах, бараа таваарын хомсдол гэх мэт саад болж байна. Киргизстан Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэн бол Казахстан одоо элсэхээр зэхэж байна. Төв Азийн орнуудын хувьд дэд бүтэц, эрчим хүч, усны асуудлаар хамтран ажиллах нь урьдынхаас илүү ач холбогдолтой болж байгаа юм. Иймд АНУ нь Киргизэд хөвөнгийн үйлдвэрлэл, Казахстанд газрын тос, Узбекстанд усны нөөцийн чиглэлээр хамтран ажиллаж байна. Мөн зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсгийн технологийн гэмтэл гэх мэт асуудлаар хяналт тавихад тус бүс нутгийн орнуудад АНУ туслаж байна. ЗХУ-ын үед байсан хими, биологи, цөмийн зэвсгийн байгууламж, төхөөрөмжийг татан буулгах, устгахад АНУ тал бүрийн тусламж үзүүлж байна.

Өөрчлөлт үргэлжилж байна. Төв Азийн орнуудад улс төрийн олон ургальч үзэл тогтох талаар АНУ чармайлт гаргаж байна. Олон

зуун жилийн эрх барих уламжлал, зөвлөлтийн үеийн тоталитар дэглэмийн нөлөө тус бүс нутагт орсоор байгаад АНУ шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Энэ нь юуны түрүүнд хүний эрх, сонгууль, хэвлэлийн эрх чөлөөнд хамаарагдаж байна.

Мөн сүүлийн үед Узбекистан, Киргизстанд террорист халдлага болсон, Хэзб ут-Тахираар хүрээгээ тэлэх хандлагатай байгаа нь терроризм, экстерминизмын эсрэг тэмцэлийг үргэлжлүүлэх шаардлагатайг харуулав. Энэхүү тэмцэлд АНУ бүх талаар туслах нь зайлшгүй юм.

Дүгнэлт. АНУ-ын Төв Ази дахь стратегийн эрх ашиг нь терроризмтэй тэмцэх, зэвсэг үл дэлгэрүүлэх, эрчим хүчний асуудал хийгээд урт хугацаанд тусгаарлагдсан эдгээр орнуудыг дэлхийн хамтын нийгэмлэгт татан оролцуулах, эрх чөлөө, хүний эрхийг улам бататгах, Төв Азийн орнуудын нийгэм-эдийн засгийг цэцэглүүлэн хөгжүүлэх, орон тус бүр болон бүс нутгийн аюулгүй байдлыг ханган бататгахад чиглэгдэж байна. Төв Азийн орнуудын ард түмний өмнө тулгарч буй олон асуудлыг тэдгээр ард түмний язгуур эрх ашгийн үүднээс шийдвэрлэхэд АНУ онцгой анхаардаг нь Төв Азийн ард түмнүүдийн гүн талархалыг хүлээж байгаа юм. Төв Азийн орнуудын улс төрийн тогтолцоо, нийгэм-эдийн засаг зэрэгт оршиж буй ардчилал, зах зээлийн эдийн засагт үл нийцэх доголдолд, дутагдлыг арилгахад нь АНУ-ын оролцоо цаашид ч шаардлагатай байсаар байх болно.